




Үндэстэй бүхэн ургаж, үртэй бүхэн цэцэглэж буй зуны дунд сарын мэндийг эрхэм уншигч та бүхэндээ өргөн дэвшүүлье.

Эдүгээгээс наян жилийн тэртээ 1939 оны 5 дугаар сарын эхээр харийн түрэмгийлэгчдийн эсрэг Халхын голын дайн эхэлж намар намжсан түүхтэй. Эх орныхоо бүрэн бүтэн байдал, эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө хийсэн энэ ариун дайныг ялалтад хүргэхэд амь, биеэ хайрлалгүй эрэлхгээр тулалдаж цусан гавьяа байгуулсан Лодонгийн Дандар, Цэндийн Олзвай тэргүүтэй эрэлхэг баатар, эх оронч олон аавын хүү эндээс тодорсон. Энэ бол улс төрийн тэмцлийн шуурга байлаа.

Одоогоос дөчин жилийн өмнө буюу 1979 онд зүүн аймгуудыг хамарсан, удаан хугацааны хүчтэй шуурга болсон. Тал, говийн газрын хөрс бараг хусагдаж, энд тэндгүй ил гарсан хар чулуунууд шовойж байлаа. Гэвч зун болж бороо чийг үзээд өвс ногоо урган, ургасаар хэвийн болдог юм билээ. Энэ бол байгалийн үзэгдэл байлаа.

Тэгвэл өнөөдөр Монголд юу болж байна? Зунаар зуд болох нь холгүй цас, бороо холилдон орж, салхи шуурга намдахгүй, төлөө бойжуулж, тариагаа тарихад төвөг бэрхшээл учруулсаар, төр засгийн түвшинд ч эд хөрөнгө, эрх тушаалын төлөө алаан, тулаан болсон хэвээрээ, шуналын дэв, хэрүүлийн бузар нь тэнгэр задрааж, мал турааж, хүн ардаа ядраасан янзаараа...

Ийнхүү байгалийн болоод нийгмийн давхар “дарлал”-д эгэл жирийн иргэд нэрвэгдсээр, ирээдүй хойчисын маань хувь заяа бүдгэрсээр байна

Байгалийн ямар ч хатуу ширүүн сорилтыг давж үндэстэй бүхэн ургаж, ундрэгатай бүхэн бургилдаг жамтай. Тэгвэл үндэстэн оршин тогтнохын үндсийн үндэс болсон өндөр соёл, хэл, бичиг, өвөрмөц зан заншилтай, баялаг түүхтэй, байгаль эхээ дээдэлдэг ард түмэн ямар ч бэрхшээлийн өмнө сөхрөхгүй, тэмцэн босож, тэсэн үлдэх нигууртай. Үүний нэг тасалж болшгүй алтан шижим нь манай монголчуудын ураг төрлөө мэдэж, угийн бичиг, шашдираа хөтөлж ирсэн түүхэн туршлага юм.

Өвлөн авч, үргэлжлүүлэн хөгжүүлбэл зохих энэхүү үнэт өв соёлыг сэргээн, өрх бүрийн үүдэнд хүргэж, толгойтон болгоны тархинд шингээх гэгээн үйлсийг уухайлан дэмжиж, уриалан дуудаж, Монголын ураг, удам, уламжлалын холбооноос “Ураг удам” нэртэй сонинг тав дахь жилдээ гаргаж байна.

Энэ удаа манай сонин “Эх нутаг, өв соёлоо эрхэмлэн тэтгэе” аяныг улс орон даяар өрнүүлэх үйлст зориулагдсан тусгай дугаараа өргөн барьж байна. Таалан болгооно уу !

“ЭХ НУТАГ, ӨВ СОЁЛОО ЭРХЭМЛЭН ДЭЭДЭЛЬЕ” МОНГОЛ ТҮМНИЙ ИХ АЯН ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ УРИАЛГА

Монгол Тулгар төр улс байгуулагдсаны 2230 жил, Их эзэн Чингис хааны мэндэлсний 860 жил, Монголын Эзэнт Гүрний нийслэл Хархорум хот үүсэн байгуулагдсаны 800 жил, Үндэсний Эрх Чөлөөний Хөдөлгөөний 110 жил, Ардын Хувьсгалын 100 жил, Ардчилсан Хувьсгалын 30 жилийн ойг угтан “Эх нутаг, өв соёлоо эрхэмлэн дээдэлье” Монгол түмний их аяныг ЮНЕСКО-ийн батламжит ТББ – Байгаль, соёлын өвийг хамгаалах сан”-гаас санаачлан 2019 оны есдүгээр сараас 2021 оны есдүгээр сар хүртэл 2 жилийн хугацаатайгаар орон даяар зарлан өрнүүлэх тухай уриалга гаргаж байна.

Өнөөдөр Дэлхий дахинд нийгмийн тогтвортой, илүү хүнлэг хөгжлийг ханган бэхжүүлэхэд соёл, соёлын өвийн ач холбогдол, үүрэг, хувь нэмэр улам бүр өсөн нэмэгдэж байна.

Байгаль дэлхий, биологийн болон соёлын олон төрөл зүйлийг хадгалан хамгаалж, дархлахаас хүн төрөлхтний амьдрал, сайн сайхан байдал, хүмүүн заяа хамаарах болсныг дэлхий нийтээр улам бүр ойлгодог болжээ. Хүн төрөлхтөн энэхүү тулгамдсан асуудлаа шийдвэрлэхэд хүн төрөлхтний соёлын үнэт зүйл, байгаль, соёлын өв онцгой ач холбогдолтойг ч гүнзгий сайн ойлгож эхэлжээ.

Тийм учир НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2015 онд “2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн зорилтууд”-аа батлан гаргасан бөгөөд соёл, соёлын өвийн хүчин зүйлийг хөгжүүлж, үүрэг, хувь нэмрийг нь өргөхийг Гишүүн улс орнуудадуралсан байна.

ЮНЕСКО дэлхий даяар соёлын өвийг хамгаалах талаар эртнээс тууштай тэмцэж, “Дэлхийн байгаль, соёлын өвийг хамгаалах тухай” (1972), “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай” (2003), “Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай” (2005) Конвенцийг тус тус батлан хэрэгжүүлж байна.

Монголчууд, Монгол улсын төр, засаг ч энэ зорилгуудыг анхааралдаа авч, соёл, соёлын өвийг хадгалж хамгаалах, дэмжин хөгжүүлэх тухайд тодорхой бодлого, хууль, дүрэм батлан хэрэгжүүлж байна. “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийг 2014 онд шинэчлэн баталж хэрэгжүүлж байгааг Монголын ард түмэн сайшаан дэмжиж байгаа билээ.

Хэдий амжилт олж байгаа ч түүхэн тодорхой алдаа эндэгдэл, учир шалтгаанаас болж Монгол үндэсний олон сайхан соёлын өв мартагдахад хүрсэн, одоо



ЮНЕСКО-ийн батламжит “Байгаль, соёлын өвийг хамгаалах сан” ТББ-ын тэргүүн, МУСГЗ, Доктор, Профессор Норовын Уртнасан

хотжилт ихсэж нүүдлийн соёлын өв амьдралд уламжлагдан хадгалагдаж хөгжих орон зай хумигдсаар байгаа зэрэг нь монгол хүн бүрийн сэтгэлийг зовоох болоод байна. Үүний сацуу зах зээлд шилжиж буй энэ үед хариуцлагагүй уул уурхай, ашиг хонжоо хайсан бодол сэтгэхүй, сэтгэлзүй газар авч байгаа нь нийгмийн оюун санааны үнэт зүйл, Монголын ард түмний эрхэм нандин өв соёл цэцэглэн хөгжиж, нийгмийн амьдралд сайн сайхныг түгээх боломж, бололцоог нь бүрэн дүүрэн нээж өгөхгүй байна.

Эрт цагаас өвгө дээдэс маань аж төрөн амьдарч, амь насаараа хамгаалан хайрлаж, эрхэм танд өвлөн өгсөн эх орон, эх нутаг, өв соёлоо үл тоож, умартан, зарим тохиолдолд түүх соёлын дурсгалт газруудыг ухаж төнхөх, тонож хулгайлах, тахилга шүтлэгтэй ариун дагшин газар нутгийг ухаж сэндийлэх, эвдэлж сүйтгэх зэрэг бусармаг үйлдэл газар авч дасал болж байгаа нь эмгэнэл юм.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг өргөн хүрээнд таниулж ойлгуулахгүй байгаагаас хэрэгжилт хангалтгүй, нийт олон,түүний дотор залуучуудын соёлын өвийн талаарх мэдлэг, ойлголт дутмаг, байгаль, соёлынхоо өвийг хадгалж хамгаалах бодол ухамсар, бишрэл бахдал, итгэл үнэмшил баттай төлөвшиж тогтохгүй байна.

Эх нутаг, байгаль, соёлын өвөө хадгалжхамгаалжтэтгэнхөгжүүлэхнь улс орны хөгжил цэцэглэл, үндэсний бодол ухамсар, бахархал болон эх оронч үзэл санааны эх үндсийг бат бэхээр бөхөлж, Монголын онцлогтой өвөрмөц сэтгэлгээ, бүтээл туурвил, үйлдвэр үйлчилгээний эх ундаргыг оргилуулан бадрааж байгаа хэрэг юм. Хүмүүс, түүний дотор залуу үеийнхэнд багаас нь эх орон, эх нутаг,

өв соёлоо гэсэн сэтгэл, сэтгэхүй, идэвх оролцоо, хичээл зүтгэл суулгах нь ардчилсан нийгмийн зорилго, зах зээлийн харилцааны мөн чанарт харшлахгүй бөгөөд харин ч нийгэмд хүнлэг энэрэнгүй, шударга, бүтээлч, чөлөөт харилцаа, уур амьсгал бүрдүүлэхэд ач тусаа өгнө гэдэгт итгэж байна.

Энэ бүхнээс ургуулваас Монгол улсад эх оронч үзэл, сэтгэл болоод байгаль, соёлын өвийг хамгаалж, тэтгэн хөгжүүлэх зорилт бол төр засгийн, байгаль орчин, соёлын асуудал хариуцсан яамдын үүрэг төдийгүй монгол хүн бүр, Монгол улсын иргэн бүр, ураг удмынхан, нутаг усныхан, айл өрх бүр, төрийн болон төрийн бус бүх байгууллага, түүний дотор бүх шатны сургууль, боловсрол, соёлын байгууллага, шашны байгууллага, мэдээллийн бүхий л хэрэгсэл, аж ахуйн нэгж байгууллага, сум, багийн Засаг даргын идэвхтэй үүрэг оролцоог шаардсан, бүх нийтийн үйл хэрэг гэдэг нь ойлгомжтой.

Учир иймд дээр дурдсан Монголчуудын түүхийн бахархалт үйл явдлуудын тэмдэглэлт их ойнуудыг угтан эх орон, эх нутаг, байгаль, соёлын өвөө хайрлан хамгаалж, тэтгэн дээдлэхэд хүн бүр, байгууллага бүр оролцож, өөрийн хувь нэмрээ оруулсан бүх нийтийн үйл хэрэг болгох зорилгоор “ Эх нутаг, өв соёлоо эрхэмлэн дээдэлье” Монгол түмний их аянг улс орон даяар өрнүүлэх нь үр дүнгээ өгнө гэдэгт бид эргэлзэхгүй байна.

Энэ Их Аяныг амжилтанд хүргэхэд хүн бүрийн оролцоо, хүчин зүтгэл хэрэгтэй байна. Монгол улсын төр, Засаг Их Аяныг зохион байгуулахад бүх талын дэмжлэг үзүүлж, хүн бүрийн эх орноо, өв соёлоо гэсэн халуун оргилуун сэтгэлийг бадрааж бүх нийтийн үйлс болгоосой гэж бид хүсч байна.

Монголчуудын энэхүү Их Аяныг өрнүүлж, зохион байгуулахад Монгол улсын БОАЖЯ, БСШУСЯ, Соёл Урлагийн Газар, Аймаг, хот, сум, дүүрэг, багийн Засаг даргын Тамгын Газар,бүх шатны сургууль, соёлын байгууллага, шашны байгууллага, залуучуудын болон ахмадын байгууллага, ТББ-ууд, улсын болон хувийн ААН байгууллагууд, ард иргэд идэвхтэй оролцон дэмжиж үндэснийхээ өв соёлыг хайрлан хамгаалж, дээдлэн хөгжүүлэхийг уриалж байна.

2018 оны 10 дугаар сарын 17.
Жич: Уриалгыг Монгол улсад ажиллаж байгаа 100 гаруй ТББ, 2018 оны 10 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо чуулсан “Монгол улсын Соёлын өвийн Анхдугаар Зөвлөглөөн”-ний бүх оролцогч гарын үсгээ зурж дэмжсэн болно.



“ЭХ НУТАГ, ӨВ СОЁЛОО ЭРХЭМЛЭН ДЭЭДЭЛЬЕ” МОНГОЛ ТҮМНИЙ ИХ АЯН

УРАГ УДАМ, МОНГОЛ ХҮН БҮРИЙН ЭРХЭМЛЭН ГҮЙЦЭТГЭЖ ХЭВШҮҮЛЭХ 10 ЗҮЙЛ

“Эх Нутаг, Өв Соёлоо Эрхэмлэн Дээдэлье” Монгол түмний Их аяны хүрээнд дор дурдсан ёс заншил, зан үйлийг хэвшил болгохыг санал болгож байна. Үүнд:

1 Айл өрх бүр угийн бичгээ нандигнан хөтөлж, он оноор баяжуулж, үр хүүхдүүддээ зааж сурган өвлөж байх, ураг удмын уулзалт, баяр хийж, шүтээн газар нутагтаа хүндэтгэл үзүүлж байх;

2 Өвөг дээдсээс ураг удамдаа үе дамжуулан уламжлан үлдээсэн газар нутгийнхаа газар усны нэрүүд, шүтээн болгон хайрлан тахиж ирсэн газар нутаг, байгаль, түүх соёлын дурсгалууд, өвөг дээдэс, ураг удмынхаа оршоон шүншиглэж ирсэн ариун газруудыг олж тогтоон, тэдгээрийн түүх, утга учир, бэлгэдэл, үлгэр, домог яриа, ерөөл, магтаал, зохиол бүтээл гэх зэрэг холбогдох мэдээллээр баяжуулж, үр хүүхдэддээ ярьж ой ухаанд нь суулган сэтгэлд нь шингээж байх;

3 Ураг удмаараа уламжлан тахилгын зан үйл хийж ирсэн газар нутаг (уул ус, гол мөрний эх, хөшөө дурсгал, онцгой хад, мод гэх мэт), түүний орчин тойрныг аль болох онгон дагшин байдлаар нь хамгаалж тэтгэх, улам бүр гоё сайхан үзэмжтэй болгож, агуулга бэлэгдэлд нь нийцүүлэн засаж, тохижуулах, ариутган цэвэрлэх, байгалийн гамшиг (үер ус, гал түймэр, аянга цахилгаан)-аас урьдчилан сэргийлэх, цаг уурын өөрчлөлт, дулаарал, цөлжилт, хуурайшилт зэрэгт дасан зохицох, сэргийлэх арга хэмжээ авах;

4 Айл гэр, ураг удам, нутаг усныхан сум, багаараа уул усны тахилгын зан үйл хийхдээ эртнээс сайтар бэлтгэж, тахилгад оролцогчид нь төрсөн, эх нутгийн шүтээн газар нутгаа өвөг дээдсээс бидэнд үеэс үед уламжилж өгсөн, тэдний бие сэтгэл, итгэл үнэмшил, өв соёл нэвт шингэсэн, юугаар ч орлуулшгүй ариун дагшин газар шороо, агаар ус гэж чин сэтгэл, сүсэг итгэл, нэн хүндэтгэлтэйгээр оролцож байх;

5 Шүтээн газар нутагтаа (газартаа) Тахилгын зан үйл үйлдэхдээ хүмүүс тэр газрын үнэ цэн, утга учрын талаар гүнзгий мэдлэг ойлголттой байх, бусдын зөв зан үйлдлийг чин санаанаасаа даган үйлдэх, шүтээн газар нутгийнхаа

тахилгын сан судрыг олж хэрэглэх, аль болохоор монгол хэлээрээ ном хурах, шүтээн газар нутгийн үнэ цэнийн тухай, энэ газрыг хайрлан хамгаалж өнөөг хүргэсэн ураг удмын болон нутаг усныхны алдар хүндтэй өвөг дээдсийн нэр алдрыг магтан алдаршуулсан ерөөл, магтаал, шүлэг найраглал туурвиж тахилын зан үйлийн үеэр олонд уншин сонордуулж байх;

6 Бөөгийн болон бурханы шашны зан үйл үйлдэхээр болбол аль болох олон түмэнд ойлгомжтой, хүнлэг энэрэнгүй, эх нутаг, өв соёл, өвөг дээдсийн ариун шүтээн газрыг хамгаалан тэтгэхэд уриалсан, шүтээн уул ус болон өвгөд дээдсийн сүнс сүлднээс сайн сайхан, аз жаргал, эрүүл энхийг болон хур бороо, ургамал ногоо элбэг дэлбэг байлгахыг аргадан хүссэн, аливаа буруу үйл, нүгэл хилэнцийг өршөөн хэлтрүүлэхийг гуйсан агуулгатай, оролцогчдын сүсэг бишрэл төрүүлсэн, оюун сэтгэлийг ариусган, таашаал сонирхол татсан байхаар гүйцэтгэж байх;

7 Тахилгын зан үйлийг үйлдэхдээ тухайн ураг удмынхан, нутаг усныхны сайн сайхан ёс заншил, ёс цээрийг даган мөрдөж, байгаль, хүрээлэн буй орчин бохирдуулах, газар шороо, мод ургамал талхлаж сүйтгэх, амьтны амь таслах, цус гаргах, хог буртаг тарих, архи дарс ууж согтуурах, хэрүүл маргаан өдөөх, цээртэй үг хэллэг хэрэглэх, ёс бус авир гаргах зэргийг хатуу цээрлэн, хууль ёс, дэг жаягийг эрхэмлэн сахиж, чухамхүү өвөг дээдсээс бидэнд уламжилсан газар нутгаа эрхэмлэн тэтгэх оюун сэтгэлээр хандаж байх;

8 Айл гэр, ураг удмаараа, угсаатны бүлэг, нутаг усаараа сум, орон нутгаараа тахилгын зан үйл хийхдээ түүнийг угтан шүтээн уул ус, тэдгээрийн хөрс шороо, гол горхи, нуур цөөрөм, ургамал, ан амьтан, түүх соёлын дурсгалт газруудыг хамгаалах, сурталчилан алдаршуулах ажлыг өрнүүлж, тахилгын гол шүтээн болох овоог уламжлалт ёсоор нь сэргээн засч, аливаа хог, учир утгагүй уяж орхисон хадаг, дарцаг, мод, төмрөөс нь цэвэрлэн, тахилга үйлдэхэд зохимжтой, үзэмжтэй, гоё сайхнаар засаж бэлтгэх, тахилгын зан үйлийн үеэр байгаль орчноо бохирдуулж гэмтээхгүй, ямар ч хог хаягдал тарихгүй

байх дэг журам тогтоон, зан үйлийн дараа цэвэрлэгээ хийж, нөхөн сэргээж байх заншлыг тогтоон бэхжүүлэх;

9 Угсаатны бүлэг, ураг удам, гэр бүл бүр багаасаа төрж өссөн шүтээн газар нутаг, уул усаа танин мэдэхэд хүүхэд залуучуудад зүйл бүрээр туслаж дэмжих, тухайн сум, аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын үзэх хичээлүүдэд уугуул нутгийн уламжлалт соёл, язгуур урлаг, ёс заншлын тухай сэдвүүдийг тусгаж, багш нарын судалгааны сэдэв болгож хэвшүүлэх;

10 Сум, баг, соёлын төв, сургуулиас “Эх нутаг, өв соёлоо эрхэмлэн тэтгэе” Их аяны зорилго, утга учир, ач холбогдолыг нутгийн иргэд, ураг удмынхан, хүүхэд залуучуудын дунд өргөн сурталчилж, орон нутгийн шүтээн газар нутаг, түүх соёлын дурсгал, уугуул нутгийн ёс заншил, аман соёл, язгуур урлаг, ардын тоглоом наадгай, баяр ёслолыг таньж мэдэх, сурч өвлөх, хамгаалан тэтгэх тухайд чуулган, өдөрлөг, уулзалт, семинар, эрдэм шинжилгээний хурал, сургалт судалгаа хийх, уран бүтээл туурвих гэх зэрэг олон талын ажил хийх; Дээр дурдсан ёс заншил, соёлын өв, зан үйлийг хэвийн болгон төлөвшүүлэх үүднээс Их Аяны хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх болно. Үүнд:

i) Монгол нутаг дахь ураг удам, нутаг усныхны тахилга шүтлэгт газар нутгийн талаар шинжлэх ухааны судалгаа хийж, тэдгээрийн хадгалалт хамгаалалтын болон тахилгын зан үйлийн өнөөгийн байдалд үнэлгээ өгч цаашид тэтгэн бэхжүүлэх арга замыг боловсруулах (2019);

ii) Ураг удам, нутаг усныхны тахилга шүтлэгт газар нутгийн тодорхойлолт гаргаж, тэдгээрийн бүртгэл мэдээллийн үндэсний нэгдсэн сан байгуулж нийтэд хүртээлтэй болгох (2019-2020);

iii) “Ураг удмынхаа шүтээн газар нутгаа эрхэмлэн дээдэлье” уриан дор Эх нутаг, өв соёлоо хайрлан хамгаалж, тахилгын зан үйлээ үлгэр жишээ үйлдэж байгаа тэргүүн туршлагын уралдааныг ураг удмынхны дунд зарлан дүгнэх, шагнаан урамшуулах (2019 оны IX – 2021 оны VI сар);

iv) Уул ус тахин шүтэх уламжлалт соёлын асуудлаар Үндэсний семинар зохион байгуулж, ББСӨ (биет бус соёлын

өв) болон тахилгын зан үйлийн шинэ үеийн өвлөн уламжлагч тусгай сургагч багш нарыг сурган бэлтгэх (2019 оны V, IX сард);

v) Сум бүрээс СББӨ болон уул усны тахилга шүтлэгийн зан үйлээр өвлөн уламжлагч багш нарыг бэлтгэх зорилгоор аймаг бүрт семинар зохион байгуулж сургалт хийх (2019 оны X, XI сард);

vi) Ураг удам, уламжлалын Холбоо (УУУХ) сум бүрт ураг удмын шүтээн газар нутгийн хамгаалалт, тахилгын зан үйлийг хариуцсан хүнтэй болж, тахилгат газар нутгийн тодорхойлолт гаргах, ураг удам, нутаг усныхны дунд зарласан тэргүүн туршлагын уралдааныг зохион байгуулахад сумын Соёлын өвийн төвтэй хамтран ажиллаж сум, аймаг, улсын бүртгэл мэдээллийн сан үүсгэн байгуулахад дэмжлэг үзүүлэх;

vii) Их аяны талаар телевиз, радио, олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр өргөн сурталчлахын зэрэгцээ Байгаль, соёлын өвийг хамгаалах сан, Соёлын өвийн үндэсний төв, Ураг, удам, уламжлалын холбоо, Монголын соёлын ажилтны “Хөгжлийн Эрин” холбоотой хамтран “Ураг удам” сонин, “Соёлын давалгаа”, “Соёлын өв” сэтгүүлээр тогтмол мэдээлж сурталчилж байх (2019-2021);

viii) “Эх нутаг, өв соёлоо эрхэмлэн дээдэлье” Их аяны тухай танилцуулга ном, хангай болон говийн бүс нутгийн онцлогт нийцсэн сурталчилгааны ном гаргаж бүх сумын Соёлын өвийн төвд хүргэж сурталчлах (2019-2021);

ix) Их аяны тухай сургуулийн хүүхдүүдэд зориулсан тусгай сонин гаргаж бүх сургуульд хүргэж сурталчлах (2019 оны VIII сард);

x) Жил бүр “Хөшөө дурсгал”, дурсгалт газрын олон улсын өдөр (4-р сарын 18)-т зориулан “Өв соёл” эчнээ уралдааныг дунд сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд зарлан дүгнэх (2020, 2021 он);

xi) Дунд сургуулийн сурагчдын дунд “Эх нутаг, өв соёлоо дээдэлье” хөдөлгөөн өрнүүлж, нутаг усныхаа дурсгалт газар, хөшөө дурсгал, тахилгат газарт хүндэтгэл үзүүлж байх, Хөшөө дурсгал, дурсгалт газрын олон улсын өдрөөр эко болон соёлын аялал, уулзалт, хурал, үзэсгэлэн зэрэг олон талын арга хэмжээ зохион байгуулах;

xii) “Эх нутаг, өв соёлоо эрхэмлэн дээдэлье” Монгол түмний их аяныг дүгнэн, ураг удам, нутаг усныхны уул, усны тахилга шүтлэгийн ёс заншил, зан үйлийн Их наадам зохион байгуулах (2021 оны VI сард).

■ Ураг удам лавлах

Тахилга шүтлэгт нутгийг судалж тодорхойлоход анхаарах зүйлс

- Тахилга шүтлэгт газруудын нэрс
- Тахилга шүтлэгт газрын байршил: Аль аймаг сум, багийн нутагт ямар нэртэй газар байдаг.
- Тахилга шүтлэгийн зан үйлийг хэдийнээс сэргээсэн
- Тахилгад оролцогчид: Тухайн газрыг тахихад хаанаас ямар ураг удмын хүмүүс голчлон оролцдог.
- Хэрвээ тахилгыг сум орон нутаг, ураг удам, сүм хийдээс эрхлэн явуулдаг бол гол гол оролцогчийн овог нэр, нас, хаяг
- Тахилга хэзээ голдуу болдог.
- Тахилгын зан үйлийн дэс дараа, дэг ёсыг тайлбарлан бичих
- Тухайн газрыг хэдий үеэс тахин шүтэж ирсэн уламжлал болон ямар хүмүүс тахиж ирсэн, тэр шүтээн нутгаас төрсөн түүхэн хүмүүсийн тухай тодорхой бичих, хэрвээ байдаг бол гэрэл зургийг хавсаргах.
- Тахилга шүтлэгт газартай холбогдох уншлага, магтаал, сан судар ном байдаг эсэх, хэрвээ байдаг бол одоо хаана хэнд хадгалагдаж байгаа \

- хавсаргах\
- Тухайн тахилга шүтлэгт газартай холбогдох домог, түүх, хууч яриа,
- Тухайн тахилга шүтлэгт газарт холбогдох хорио цээрийн ёс
- Тухайн тахилга шүтлэгт газрын лус, савдаг, эзэдтэй холбогдох домог яриа.
- Тэдгээрийг дүрсэлсэн зураг байдаг бол хэнд хадгалагдаж байдаг боломжтой бол зургийг нь оруулах.
- Тахилга шүтлэгт газарт зориулсан магтаал, дуу, хуур байдаг эсэх, байдаг бол хэн хэнд өвлөгдөж байдаг.
- Тахилга шүтлэгт газарт зориулан зохиогдсон орчин үеийн дуу, хуур ерөөл, магтаал, ном, товхимол байдаг бол хавсаргах
- Ураг удмынхны оршуулгын дурсгалт газар хаана байдаг, хэрхэн арчилж хүндэтгэл ёслол үзүүлдэг.
- Тухайн тахилга шүтлэгт газар, түүнийг хүрээлсэн нутагт түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд (хадны

- зураг, хөшөө чулуу, буган хөшөө, суварга гэх мэт) байдаг эсэх, байвал нэр, байршил, товч тодорхойлолт үнэ цэнийг бичих
- Тахилга шүтлэгт газар, түүнийг хүрээлсэн нутагт ариун булаг, рашаан ой, нуга, байгалийн үзэсгэлэнт газар байгаа эсэх, байвал нэр, байршил, товч тодорхойлолт, үнэ цэнийг бичих
- Тухайн тахилгат газрын гэрэл зураг
- Тахилгын зан үйл, ард түмний төлөөлийг харуулсан гэрэл зураг
- Тухайн тахилгат газар нутаг болон түүнийг хүрээлсэн нутгийг хадгалж хамгаалах, тахиx талаар ямар ямар арга хэмжээг хэрхэн авч хэрэгжүүлсэн.
- Тухайн тахилга шүтлэгт газрыг хадгалж хамгаалах, сурталчлах талаар ямар арга хэмжээ авч байгаа (хавсаргах)
- Тухайн тахилга шүтлэгт газар, түүнийг хүрээлсэн нутагт эко болон соёлын аялал жуулчлал хөгжиж байгаа эсэх; хөгжиж байгаа бол ямар маршрутаар юу үзүүлдэг.

Монголчуудын газар нутаг дахь тэнгэрийн идэвхжил дахин сэргэж буй цаг үе дор бид амьдарч байгаа. Тэнгэрийн идэвхжлийн үе нэгэнт эхэлсэн бол өвөг дээдсийн онгод сүнсний мэдээлэл дахин идэвхждэг. Энэ бол зэрэгцэн явдаг зүйл юм. Өвөг дээдсийн онгод сүнсний мэдээлэл идэвхжээд ирэхээр ерөнхийдөө байгалийн хуулийг байнга сахин мөрдөж байсан монголчуудын хувьд юу юу нь зөрчигдсөн, юу юу нь зөрчигдөөгүй байна гэдэг нь өвөг дээдсийн оюун ухаан мэдээллээр дамжуулан хэлдэг юм. Үүнтэй уялдуулан өнөөгийн монголчуудын байж байгаа царай, эв нэгдэлгүй, байгаль дэлхий оршихуйгаа сөнөөж, байгалийн тогтмол хуулиудыг зөрчиж байгаа байдлуудтай өвөг дээдсийн оюун ухаан санал нийлэхгүй, анхааруулж хэлэх нь зүй ёсны хэрэг. Ийм цаг үед бид амьдарч байна. Үүнтэй улбаалаад Бурхан Халдун хайрханы Дээд Цагаан аралд монголчуудыг нэгтгэн барьдаг байсан овоо тахилгын зан үйлийг дахин сэргээх даалгаварыг дээд тэнгэрээс удаа дараалан өгсний дагуу хэсэг хүмүүс сэтгэл гарган зүтгэж байгаа. Монголчууд эв нэгдэлгүй, тархай бутархай, тал тал тийшээ бутарч сарниж байгаа нь хэн бүхэнд ойлгомжтой зүйл. Эв нэгдэлтэй байна гэдэг бол байгаль цаанаа бас эв нэгдсэн байх учиртай. Хүннүгийн нутаг дээр байгаа уул хайрханы эзэн савдагууд ерөнхийдөө нэгэн захиргаан дор Бурхан Халдун хайрханыхаа том эзэн савдагуудын дор захирагдаж байдаг. Үүний тусгал нь ил ертөнц дээр монголчууд бид нэгэн захиргаан дор захирагдаж, ил далд хоёр хүчний нөлөөлөл энд илэрч гарч ирж байгаа. Овоо тахилгын учир холбогдол бол энд тэндэхийн ураг удмын овоо, овгийн овоо, төрийн овоо гэх мэтчилэн гучин зургаан төрлийн овоо байдаг. Энэ дотроос хамгийн идэвхжиж байгаа нь улс орныхоо хэмжээнд ураг удмын нэгдлийг буй болгохын тулд төв цэг нь Бурхан халдун хайрхан хэзээд байсан ба 13 дугаар зуун түүнээс цаашлаад олон жилийн түүх Монголын нууц товчоонд байдгийг энд нуршаад яахав. Монголчууд маань билгийн ухаанаараа байгаль ертөнцийн тогтмол хуулиудыг танин мэдсэн учраас Бурхан Халдун хайрханаа тахьдаг өдөр улс даяараа монголчууд нэгэн цаг дор тахьдаг байсан мэдээлэл орж ирж байгаа. Ерөнхийдөө Бурхан Халдун хайрханыг нэгэн өдөр тахилаа гэхэд бүх л улсын хэмжээний ураг овооны нэгдэл, овогийн овооны баяр наадмыг нэгэн цагт хийдэг байсан. Шинжлэх ухаанчаар авч үзвэл орон зайн энергийг билэгийн ухаанаар



ЯЗГУУР СУДЛААЧ Д.БАДАРЧ: МОНГОЛЧУУД ОВОО ТАХИЛГАН ДЭЭР Л НЭГДДЭГ

хэдэн мянган жилийн тэртээгээс танин мэдэж иржээ. Эерэг юмуу эсвэл сөрөг мэдээлэл нэгэн цагт үүсэхэд, дээшээ хөөрөөд, доошоогоо эерэг сөрөгөөр нөлөөлж байдаг. Дандаа эерэг нөлөөлөл нь ган зуд, газар усны аюулгүй байгальдаа амьдарч болох боломжит бүх нөхцлүүдийг хангадаг. Энэ үүднээс овоо тахилгуудыг хийдэг байсан. Овоо тахилга бол баяр цэнгээн, тэр уулын эзэн савдаг аргадах талын ойлголт байгаад байдаг. Угтаа тийм биш юм. Уулын эзэн савдагуудтайгаа харилцан ярилцаж, тэдэнд юу хэрэгтэй байгаа, тэдний зүгээс бидэнд юу хэрэгтэй байгаа, бие биенээ нөхөн дэмжиж, байгаль хүн хоёр шүтэн барилдлагатай учраас энэ шүтэлцээг жилдээ хийгээд явдаг аргачлал. Байгаль эзэнтэй, тухайн эзэн биднээс юу шаардаж байна, хүмүүн бидэнд буруу зөрүү юу байгаа, буруу байгаа бол эзэн савдагуудтай ойлголцож, байгальтайгаа харилцан шүтэлцэж явах учиртай юм. Өөрөөр хэлбэл байгальтайгаа ярилцаж хэлэлцэж зохицон амьдрах урлаг. Энэ нь цаг нь болоод, ойлгоод хэсэг сэтгэлтэй монголчууд маань овоогоо босгоод явж байгаа. Монголчуудын эн түрүүнд

эв нэгдэлтэй байх тухай асуудал. Эв нэгдэлтэй байхын тулд аль нэг аймгийн аль нэг сумын ямар газар ах дүүсийн ураг төрлийн овоо нь бий. Өвөг дээдэс агуу их ухаантай учраас Бурхан Халдун буюу төв цэгээс салбарласан энэ хооронд эзэн савдагуудаа уул усаа төв сервер болгож нэгтгэ, үүний тусгал та бүхэн эвлэлдэн нэгдэж улс орноо босгоход үлэмж хэрэгтэй гэдэг гол санааг хэлсний үндсэн дээр энэхүү тахилга явагдаж байна. Сүүлийн 3-4 зуун жилд Монголын ариун ёс дотор суусан ёр гэж бий. Ёрын нэрмээсээс болоод овооны ажил саад бэрхшээлтэй бас удаашралтай яваа. Энэ нь байрнаасаа хөдөлсөн чулуу гурван жил зовдог, овооны чулууг хөдөлгөж болохгүй гэж сөрөг талынхан номолчихжээ. Нэгэнт манжууд наян хэдэн хошуу болгож задалсан тохиолдолд буцаад эмхлэгдэхийн тулд монголчууд юун дээрээ нэгддэг вэ гэхээр овоо тахилган дээрээ л нэгддэг. Өөр нэгдээд хурал чуулган жагсаал цуглаан хийх тогтсон соёл угаас байхгүй. Уламжлал ч байхгүй, нүүдлийн соёлд тийм боломж ч байхгүй. Манжууд нэг ураг удмын овоог нь дөрөв хувааж нураагаад, дөрвөн хошуунд

овогийг нь задлаад хийсэн. Буцаад нэгдчихвий гэхдээ маш нарийн ухаан сэдсэн байдаг. Ингэж овооны чулуунаас авч болохгүй л гэж. Би л гэхэд Говь-Алтай аймгийн Цээл сумын Хар азарганы нуруунд төрсөн. Хар Азарганы нурууныхаа чулууг би Их Монголын овоондоо залж авчирсан. Хайрханы маань эзэн савдаг Бурхан Халдуны эзэн савдагтай холбоод өгчихөж байгаа юм. Үүнтэй адил маш олон монголчууд өөрийнхээ овооны чулууг Бурхан Халдун дээр авчирч залаад тавьсан байгаа. Манжийн дарлалын үед ноёд, ихэс дээдсүүд нэг уулзаад авах далим гаргахын тулд ингэж овооны найр хийж, морь уралдуулж, бөх барилдуулж цаг хугацаагаа уртасгаж байсан бодлого байсан. Монголын төрөөс овоогоо нэгэн өдөр тал бүртээ тахих соёлоо сэргээнэ гэж найдаж явдаг. Шинжлэх ухааны үндэстэй юм. Нэгэн цаг доор олны хүчээр овоо тахилга хийхэд өндөр үр дүнтэй байжээ. Монголчууд маань өвөг дээдсийнхээ ухааныг дагаж, сургаалыг нь мөрдөж, Их Монголын овоо тахилгандаа улам идэвхтэй оролцоосой гэж хүсэж байна. Энэ нь Монголчууд эвлэлдэн нэгдэхэд, Монгол улсаа босгоход танай ураг удмын зүгээс оруулах маш том хувь нэмэр болно.

■ Ураг удам лавлах

Овоог сэргээн босгох үйлэнд нэгдэхийн утга

“Их Монголын овоо”-нд нэгдсэн удмын үрс, залгамж хойчист тэнгэрлэг өвөг дээдсийнх нь язгуур, эрхэм чанарууд сэргэн эрчимжихийн хамтаар, ураг удмын амин эрчмийн холбоос бэхжин, хүчирхэгжиж, чин итгэл, сэтгэл, эрхэм зүтгэлт үрсүүд нь үндсээсээ тэтгэгдэж, язгуураасаа өргөгдөж, зөв, үнэний төлөөх үйл бүхэн нь тэтгэгдэх учиртай.

Овоог сэргээн босгох тахилгын зан үйлийн тухай

Овоонд нэгдэхээр ирсэн удмууд

эртний ёс уламжлалын дагуу үе уламжлан тахиж шүтдэг хайрхадын овоодоос итгэл сэтгэлийн эрчмээр хурайлан, угсаа гарвал, удмын мэдээллийг таниулан шингээж, уул усны эздийн адислалыг оршоон залсан чулууг хүндэтгэлтэйгээр өргөнө. Түүнчлэн өөрөөс дээшхи 9 үеийн удмын хэл-хээг батжуулан, эрчмийн холбоосыг сэргээх, өөрөөс хойшхи 9 үеийн үр хойчистоо залгамжлуулан үлдээх утга бэлэгдэлт 9 алдын сурыг элч тэнгэрээр амилуулан хурайлж,

удмын шүтээн болгон зална.

Удмын чулууг залж амжаагүй удмуудын төлөөлөл өөрсдийн өвөг дээдэст таниулан мэдүүлж, хугацаа товлон удмын чулуугаа залахаа амлан 9 төө 9 ширхэг сураар учиг холбоогоо зангидан бэхлэх үйлээр оролцоно.

Түүнчлэн үйлд нэгдэн, үүрэгжсэн зарлигт удмууд тахилгын үеэр галын өргөл, лусын өргөл, нарны залбирлын үйлүүдийг хариуцан хийдэг.


Овоог сэргээн босгох үйл ажиллагаа

Дээд тэнгэрийн зарлигаар 2013 онд түүхэн овооны эртний суурийг тодруулан, шав тавьснаас хойш өнөөг хүртэл сэргээн босгох үйл ажиллагааг хэрэгжүүлсээр ирсэн. Одоогоор Архангай, Говь-Алтай, Баянхонгор, Дундговь, Сэлэнгэ, Төв, Говьсүмбэр, Өвөрхангай аймгуудаас болон ӨМӨЗО, ОХУ-ын Тува, Буриад улсуудаас зарим удам, угсааны төлөөллүүд Хамаг Монголын овооны үйлэнд нэгдэн, өөрсдийн язгуур, гарвалуудад хүндэтгэл үзүүлээд байна.

ЁС СОЁЛ: УРАГ

Чимэдбалдирын Дунгар “УГИЙН ШАСТИР ХӨТЛӨХ ГАРЫН АВЛАГА” номноос

Олон улсын бэлэгдэл тэмдэгээр үйлдсэн Удам төрлийн угийн зураглалын үлгэрчилсэн загварын хураангуй



Доод үе

2-р үе -Нуган хүү

3-р үе -Ач хүү

4-р үе -Гуч хүү

5-р үе -Жич хүү

6-р үе -Гучинцар хүү

7-р үе -Жичэнцэр хүү

8-р үе -Дөч хүү


9-р үе -Төч



АХАН ДҮҮСИЙН ХҮҮХДҮҮД ХООРОНДОО Үеэл байна. Үеэлийн хүүхдүүд хоорондоо ХАЯАЛ байна гэх мэтээр цааш үргэлжилнэ...

УДАМ УЛСЫН ҮНДЭС

Үлгэрчилсэн загварын дэлгэрэнгүйг Монголын Угийн бичгийг хөгжүүлэх нийгэмлэгээс танилцуулж байна





Монгол түмний хувь заяаг даатган үеийн үед өвөг дээдэс маань уламжлан тахиж ирсэн их хайрхадын ноён оргил нь Хан Хэнтийн нуруунд орших Бурхан халдун хайрхан билээ. Эрт цагаас энэ хайрханаа тахиж тайлахдаа Бурхан Халдун хайрханаас наана орших Дээд цагаан арал дээрээс тахиж ирсэн уламжлалтай байжээ. Зарим нэг түүхийн эх сурвалжид Хүннү гүрний үед эндээс Бурхан халдун хайрханаа тахиж байсан гэдэг.

Энэ уламжлал маань алдагдснаас болж Их хайрханы орой дээр нь хэн дуртай нь гарч юу дуртайгаа хийдэг

болсон. Энэ байдлыг засаж их хайрханаа эртний зан үйлийн дагуу тахиж шүтэх уламжлалаа сэргээхээр “Их Монголын Ураг удмын нэгдэл” ТТБ-аас Дээд цагаан арал дээр Монгол түмний их овоог сэргээн босгох үйлийг 2013 оноос эхлэн хийж байна. Энэ овоо маань 999 ураг удмын шүтдэг уул хайрхадын чулууны дээжээс бүрдэх өгөөд энд чулуу залсан ураг удмын хойчих 33 үе нь мөнх тэнгэр их хайрхандаа даатгагдан ивээгдэж явах учиртай билээ.

Энэ овоог сэргээн босгосноор одоо энэ цаг үед үгүй болсон ураг удмын

Д.Бэгзжав:

Их Монголын овоонд чулуу залсан ураг удмын хойчих 33 үе нь мөнх тэнгэр их хайрхандаа даатгагдан ивээгдэнэ

ургийн бичиг хөтлөх зан үйл сэргэн дэлгэрч, тухайн удмууд өөрсдийн овоо тахилгаа сэргээснээр удмууд үр удмаа даатгадаг овоогоо тахих зан үйл уламжлал сэргэж, уул хайрхад маань эзэнтэй болж, онгон дагшнаараа хойч үедээ өвлөгдөн үлдэх, нутаг ус байгалиа хамгаалах зэрэг одоо үед мартагдсан зөв зүйтэй уламжлал сэргэх ач холбогдолтой юм. Өвөг дээдэс Их хаан маань үр удамдаа захиж үлдээсэн “Их хориг” эргэн сэргэх учигтай билээ. Энэ хориг сэргэснээр Бурхан Халдун хайрханд хэн дуртай нь очиж өвгөдийн онгон дээрээ гишгүүлж буйг хориглож, зөвхөн Босго даваанаас цааш нэвтэрдэггүй, хатуу чанд мөрдөгддөг байсан уламжлалаа сэргээх юм. Эрт үед босго давааг хоёрхон тохиолдолд давдаг байв. Үүнд:

1. Ихсээ оршооход
2. Хар сүлд догшируулахад

Түүнээс бусад тохиолдолд хориглож байжээ. Учир нь энэ газар Их хааны онгон болон бусад Их бага хаадын онгон оршин буй билээ.

Одоогоор бид Монголын Их Овоог сэргээн босгох үйлээ эрт цагаас уламжилж ирсэн зан үйлээр хийж байна.

Их овоонд урам удмаа даатгахдаа удмаа төлөөлж 9 алд сур, 9 ширхэг 9 төө нарийн сур, удмын овооны чулуу болон өөрийн өсөж төрсөн, нутаг хайрханы чулууг залж, хойч үеэ Мөнх тэнгэр Их хайрхандаа даатгуулдаг билээ.

Энэ жилийн тахилга 2019 оны 6 сарын 21-23-нд Дээд цагаан арал дээр болно. Дэлгэрэнгүй мэдээллийг 90992018, 99132889 утсаар мэдээлэл авах боломжтой.

**ИМУУН ТББ тэргүүн
Д.Бэгзжав 99132889**

Удган Б.Батням: ОВООНЫХОО ҮЙЛЭНД ОРОЛЦОН, 999 УРАГ УДМЫН ТООНД БАГТВАЛ ИХ ХОВОРХОН ХУВЬ ЗАЯА, АМНЫ ХИШИГ

2009 онд онгод тэнгэрээ залж авсан. Одоо бараг 10 жил тэнгэрийн үйлэнд зүтгэж, төр улс, түмэн олны тусын тулд тэнгэрийн зарлигтай үйлүүдийг хийж явна. 2015 оноос Их Монголын овооны үйлэнд зүүд зөнгийн совингоор тэнгэрийн зариллаг хэлэгдэн, үйл нэгтэнгүүдтэйгээ мөр зэрэгцэн энэхүү их үйлэнд нэгдэнорсон. Бурхан Халдун хайрхана Дээд цагаан аралд эртний монголчуудын хүндлэн тахиж ирсэн Их Монголыг овоог сэргээн босгох үйл 2013 оноос эхлэн тэнгэрийн зарлигаар хийгдэж ирсэн. Энэ овоонд 999 ураг удмын уул овооны чулууг авчирч залснаар овооны амь бүрдэж, хүч чадал нь дэлгэрэх учиртай юм. Иймд энэ овоог сэргээн босгоход газар газрын монгол цуст хүмүүсийн туслалцаа дэмээр үйлүүд тасралтгүй хийгдсээр ирэв. Монголчууд төдийгүй дэлхийн монголчууд сэтгэл зүрхээрээ дэмжин оролцож байна. Өвөр Монгол Буриад Монгол, Халимаг, Тува, Хазаар, Монгол гэх мэтээр өргөн оролцож байна. Энэ овооны үйлэнд зориулж

Нарны тахилга
Хайрханы тахилга
Галын тахилга
Лусын тахилга

Овооны тахилга гэх мэтээрэдгээр тахилгуудыг товлогдсон өдөр зорьж очиж хийдэг. Энэ тахилганд оролцсон хүмүүс нутаг усныхаа шүтэн дээдэлдэг хайрхад, ураг удмын овооныхоо чулууг /3-9 ширхэг/ авч ирж, Их Монголын овоонд залдаг учиртай.

Лусын тахилгыг Хан Хэнтий нурууг эмжин ундаалан урсдаг Хэрлэн голын хөвөөнд тахидагаараа онцлог. Учир нь их овоог сэргээн босгохын тулд чин зүрх сэтгэлээрээ оролцож буй



олон монголчууд, дэлхийгээр тархан суурьшсан Монголчуудын төлөөлөл зорин ирж, нутаг усны шүтээн хайрхад, ураг удмынхаа овооны чулуутай ирж ирж залж байгаа юм. Энэ авчирсан чулуугаар нь дамжуулан бүх газар нутгийн лусын эздгийг дуудан Хэрлэн голын хөвөөнд чулуулж, идээ ундаа өргөл дээжээ хүртээн, хийж буй үйлээ мэдүүлж, зорин ирсэн хүмүүсийг даатган, цаашлаад нутаг усны бүрэн бүтэн байдал, төр улс, түмэн олон, зуншлага, зуд турхангүй байх бүхий л зүйлийг хурайлан тахидаг. Нэг чухал зүйл бол чулуу залж, ирсэн хүмүүсийн дунд удмын лусын хорлол бариатай хүн байхад тэд чулуугаар дамжуулан лусын эздийг дуудан аргадан лусын бариаг тавиулж засаж болдог нь зорин ирсэн хүмүүсийн сэтгэлд нь сайн хүрдэг юм. Ер нь лусын тахилгыг зөв сайхан хийхэд тэнгэр хангайн ааш араншин

зөөлөрч, хуй салхи намсан, тэнгэр цэлмэж, нар солонго хүрээ татах гэх мэт бодит үзэгдлүүл их болдог. Бидний хийж бүтээж яваа энэ их үйлст бүх монголчууд анхаарч оролцвол зохих үйл учраас та бүхнийгээ энэ овооныхоо үйлэнд идэвхтэй оролцон, 999 ураг удмын тоонд багтаж орвол их ховорхон хувь заяа, амны хишиг юм шүү. 999 монгол хүн бүр энэ үйлэнд оролцох үүд хаалга нээлттэй байгаа. Энэхүү тахилганд зүрх сэтгэлээсээ зорин ирж оролцсон хүмүүс нь лусын тахилгаар дамжуулан ураг удамдаа лусын хишиг буулган авах, цаашлаад нутаг оронд байгалийн гай гамшиг болохоос хамгаалж, зундаа хур бороо элбэгтэй, ургамал ногоо тэгш байх, өвөлдөө зудгүй өнөтэй байх тэр лусын хишгээр дамжуулан нутаг усандаа авч байгаа өргөн дэлгэр үйл юм.

ЭРТНИЙ ОВООНЫ ТҮҮХ, БЭЛЭГДЭЛИЙН ТУХАЙД



Талын нүүдэлчин Монгол овог, аймгуудын тэргүүд, удмаасаа сонгогдон угсаагаа тэргүүлэх эрхээр тодлогдогсод, олноос онцгойрон гавьяат үйлсээрээ оройлон танигдагчид, удам угсаа, уул ус өлгий нутаг, ав соёлынхоо үнэт өвийг өртөөлөн уламжилж, хариуцан хамгаалж, өвлүүлэх үүрэгтэй, зарлигтай улаач, увидастнуудхуран цуглаж, Нэгдмэл их улсыг байгуулснаа Мөнх тэнгэрт мэдүүлэн, эгнэгт алдрашгүй нэгдмэл хүчирхэг байхын бэлэгдэлт эвийн хэлхээгээ батжуулах андхай өргөн, ёсыг гүйцэтгэн “Их Монголын овоо”-г байгуулжээ.

Овоонд нэгдсэн овог, аймаг, удмууд Мөнх тэнгэр хийгээд Монгол төрийн сүлдэд мөнхөд ивээгдэхийн соёрхолыг хүсч, үеийн үед, үр удмаараа үнэнч сэтгэл, үйл хэргээ өргөж явахаа андхайд байв. Нэгдмэл Монголын эв нэгдэл, эрх ашгийг өөрсдийн овог, аймаг, удмаас илүү дээдэд эрхэмлэх үүднээс үе уламжлан тахиж шүтдэг хайрхадын овоодоос итгэл сэтгэлийн эрчмээр хурайлагдсан угсаа гарвал, овог аймаг, удмын мэдээллийг таниулан шингээж, уул усны эздийнх нь адислалыг оршоосон чулууг дээжлэн залах байдлаар эртний сурвалжит овоог бүтээжээ.

Хан төрийн сүлд, хаад эздийн сүр орших Их халдун хайрханы эвийн гэгдэх Дээд цагаан аралд босгосон энэхүү овоог төрийн төвшинд тусгайлан тахих үед овоонд чулуугаа өргөн, үнэн сэтгэл, үүргээрээ нэгдсэн удмууд Мөнх тэнгэрийн ивээл, Өндөр төрийн өршөөлд багтан соёрхогддог хэмээн дээдлэн сүсэлдэг байв.

Өв судлаач Р.Сэлэнгэ



“Генетика” буюу “Гарвалзүйн ухаан” хэмээн нэрлэж шинжлэх ухааны шинэ урсгал болгон хөгжүүлж эхэлсэн тэр л онолын үндсэн тулгуурын нэг нь монголчуудын олон зуун жил хөтөлж ирсэн “Угийн бичиг” юм.

Монголчууд ургийн түүхээ бичгээр хөтөлсөөр бараг 1000 жил болжээ.1575 онд төрсөн сэцэн хан Шолойн гэрийн үеийн бичмэл гэхэд л 328 жилийн урт хугацаанд амьдарч асан 11966 хүний нэр, 5 ханатын буйран чинээ том даавуунаа

ӨВГӨДИЙН УХААНЫГ ӨВ БОЛГОЁ

Монгол улсын Засгийн газрын 2007 оны 257 дугаар тогтоолоор “Угийн бичиг хөтлөх журам” батлагдсан. Энэхүү журмын 1 дүгээр зүйлийн 1.2-т “Монгол улсын иргэн бүр ... өөрийн ураг төрлийн хамаатлын хүрээгээ тогтоож, үр удамдаа заавал өвлүүлэх үүрэг хүлээнэ”, мөн зүйлийн 1.4-т “Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга харьяа нутаг дэвсгэрийн нийт өрхийн хэмжээнд өрх бүрийг угийн бичиг хөтлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах үүрэг хүлээнэ” гэж тус тус заажээ. Төр засгийн энэхүү шийдвэрийг хэрэгжүүлэх ажиллагаа хүлээгдэж байна.

Удмын сан буюу цусан хэлхээгээ бохирдуулалгүй хадгалж, улс гүрний үнэн түүхээ бүтээж ирсэн аль VIII зуунаас хойшхи 1300 орчим жилийн өв их уламжлал, ёс заншлаа сэргээн хэрэглэх тухайлбал, угийн бичиг хөтлөх, угсаа гарвалаа хойч үедээ таниулах, ургийн баяр хийж хол ойрын ах дүүсээ

бичигдэн үлджээ.

Угийн бичиг зөвхөн язгууртны гэрт төдийгүй эгэл хүмүүсийн цээжинд, аман дурсамжаар өвлөгдөн үлджээ.

Сүүлийн үед Хүн судлалын үндэсний төв /Захирал нь ШУГЗ Ж.Батсуурь/ “Хүн ам дахь цус ойртолт үндэсний гамшгийн хэмжээнд хүрчээ” гэдгийг нилээд хүчтэй ярих болсон нь чухал ач холбогдолтой байна. Манай хүн амын 97,24 хувь нь шууд, 2,76 хувь нь алсуур цус ойртсон гэж үзээд эрдэмтэн Ж.Батсуурь, Э.Энхмаа нар “Түгшүүр” зарласан ажээ. Үүнд цочрол авмаар асуудал боловч эрх баригчид дүлий мэт суусаар үе залгамжилсаар байна.

“Цус ойртоход” нөлөөлсөн гол гайг ч эрх баригчид тарьсан гэж болно.



өөр хооронд нь танилцуулах, ахас ихсээ танин мэдэж хүндэтгэл, дээдлэл үзүүлэх үйл хэрэг сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц идэвхжиж байна. Энэ идэвхжилийг хөгжөөх шаардлагатай байна.

1921 оноос өмнө угийн бичгийг “гэрийн үеийн бичмэл” гэж нэрлэн түүнийг төрийн албан баримт хэмээн үзэж, нарийн чанд ёс журмын дагуу хөтөлдөг байжээ. Богд хаант Монгол улсын үед дотоод яамнаас эрхлэн ноёд, тайж нарын гэрийн үеийн бичмэлд тодорхой хугацаанд нэмэлт хийдэг хуультай, уг баримт бичгийн эхэнд хэний гэрийн үеийн бичиг болох, төгсгөлд нь хэзээ үйлдсэнийг тэмдэглэж, харьяат аймаг, хошууных нь тамгыг

ҮНДЭСТНИЙ ҮНДЭС НЬ ҮР ХҮҮХЭД

Учир нь улсынхаа нийт хүн амын тал хувийг нийслэл хотдоо бөөгнүүлэн шахцалдуулсан нь засаг, төрийн үе,үеийн олон шатны албан хаагчдын балаг юм. Хүн амаа нэг хонхорт төвлөрүүлэх нь дор хаяад л үндэсний аюулгүй байдалд харш үзэгдэл. Наад захын аюул гэхэд л цусан төрлийн холбоотой хүмүүс /залуус/ хоорондоо гэр бүл болж эхэлснээс цус ойртолт эх авсаар байна.

Тэдэнд, тэдний эцэг эхэд угийн бичиг байхгүй, бүүр 1925 онд Засгийн газар овог хэрэглэх, угийн бичиг хөтлөхийг хориглосон нууц тогтоол гаргачихсанаас хойш голдуу төрсөн хүмүүс юм. Тэр дээр үед хэдэн “хувьсгалч нар” ийм “биотероризм” санаачилсан биз ээ.

Цус ойртсоны улмаас 19 бүлэг өвчин,

дарж батламжилдаг байжээ.Түүнчлэн гэрийн үеийн бичмэлийг ташаа бичиж самууруулахад хүргэвээс уг үйлдсэн бичээч, түшмэл нарыг ташуураар занчиж хатуу шийтгэдэг байв. Харамсалтай нь энэхүү үнэт түүхэн уламжлал маань 1925 оноос БОКБН-ын зориудын бодлого, шахалтаар бүрэн хаагдсан байна. Энэхүү түүхэн уламжлалыг сэргээн хэрэглэх шаардлагатай боллоо.

Тэнгэр эцэг монгол түмнийг 2000 жил хүчирхэгжүүлж, идэрмэгжүүлж, чийрэгжүүлж, ухааруулсан их өв санг үлдээсэн.

Гурван сая Монгол хүний дундаас олимп, дэлхийн олон аваргууд төрөн гарч, мэрэгжлийн сумогийн түүхэн дэвжээг удаан хугацаанд эзэгнэн, дэлхийн миссийн дэвжээг чичрүүлж, дэлхий дахины чихийг дэлдийлгэж, нүдийг бүлтийлгэсэн онцгой чадвар эцэг дээдсийн их өв, уламжлалаас шууд улбаатай. Энэ гайхамшигт чадамжийг бэхжүүлэх явдал хөх толбот Монгол овогтны эрхэм ашиг сонирхол мөнөөсөө мөн.

Тэнгэр эцэг биеэ засахуйн эрдэм билиг сургаалд буй, гэрээ засахуйн эрдэм гэгээрсэн хүмүнд буй, төрөө засахуйн эрдэм сэцэн билигтэнд буй хэмээж бие

32 төрлийн хорт хавдараар өвдөх, тэр ч байтугаа уруул тагнай нь сэтэрхий, нугас нь ивэрхий , зүрхний гажигтай, хошного нь битүү... гэхчлэн согогтой төрдөгт хүргэдэг ажээ. Энэчлэн бие махбодийн 10 төрлийн согогтой хүүхэд сүүлийн үед төрдөг болсон нь цус ойртолтын хөнөөл гэдгийг эрдэмтэд нотолсоор байна.

Хүүхэдгүй л болчихвол үндэстэн мөхөх замдаа орох нэгдүгээр аюултай тулгарах учраас энэ тухай яриад байгаа хэрэг. Сүүлийн үед “Угийн бичиг” хөтлөх санаачилага зарим хүмүүс гаргаж байгааг сайшаан дэмжүүштэй билээ.

Монгол улсын хөдөлмөрийн баатар, СГЗ, төрийн соёрхолт, Ардын уран зохиолч, доктор Л.Түдэв

хүн, айл өрх, төр засгийн өөр хоорондын ариун холбоо буюу алтан аргамжийг уялдуулан зангидсан. Энэ алтан аргамжааг чангалах, бөхлөх шаардлагатай байна.

Тэнгэр эцэг мөнх тэнгэртэй харьцаж, уул овоогоо аргадан тахиж, энэ хэрээр хангай дэлхийгээ байгаль орчиноо, газрын доорхи их баялагаа ариглан хамгаалж, хүн байгалийн амин холбоог иргэн бүртээ таниулж ухааруулсан. Их ухаарлын энэхүү далайгаас хүн бүрт дээжлэн хүртээхийг амьдралын хүрд байнга шаардаж байна.

Бүхнийг зоосны нүхээр харж “мөнгө улаан, нүд цагаан” болсон өнөө үед Ахмад залуу үеийн залгамж холбоог бэхжүүлэх, удамших хойч үеэ өндөр ёс зүй ,ёс суртахуун, мэдлэг боловсролтой болгон хүмүүнжүүлэх, дэлхий ээжээ энхрийлэн хайрлах үр өгөөжтэй, шалгарч шигшигдсэн арга, билгээ заавал ашиглан дагах шаардлагатай байна.

Цөөн тоотой Монгол үндэстнийг мөхөлд хүргэлгүй өнөөдөртэй золгуулсан учир шалтгааныг олох гэсэн дотоод гадаадын сонирхогчид, эрдэм-тэд, судлаачид, жуулчдын эгнээ улам бүр өргөжиж байна. Манай уламжлалт өв, их ухаарал нарт замбуулинд хүртээмжтэй байх ёстой.

Судлаач Жамцайн Баасандаш



УС ТЭНГЭРИЙН ХЭМЖЭЭГЭЭР БИЙ

Би уул нь усны барилгын инженер мэргэжилтэй, цаас муухай болгогч юм л даа. Зарим хүн цоргоо нээгээд ус байна гэж хэлдэг. Ингэж хэлэх нь учир дутагдалтай. Ус тэнгэрийн хэмжээгээр бий. Усаар Улаанбаатар хэзээч гагцгдах ёсгүй.

Туул голоо хэзээ ч ширгээхгүй байх арга энд л буюу тэнгэрт л бий. Тэнгэр хэмээх аугаа шүтээн бидэнд мөнхийн цэнгэг ус хайрлана. Тэнгэрээс буусан тэр усыг далангаар хаагаад нуур тогтоогоод авбал уу, хүсэл бүхнийг биелээх чандмань эрдэнийн үлгэр эхэлнэ.

Ер нь гол, горхи, булаг эх авсан аваагүй уулын ам бүхэн надад алтан аягатай ус мэт санагддаг. Дамаа, хуурайшин хатаж буй байгаль, дэлхий шархандаа шаналж буй энэ үед арга байхгүй, авралын алтан аягатай ус шүү.

Гол бүхнийг нууран тэжээлтэй болговол ширгэх гамшгаас айхааргүй болно.

Иймээс би, нийслэлчүүддээ Туулынхаа уснаас уухаа больё. Туулын эх өөд далан барьж, тэнгэрийн ус хуримтлуулан түүнээсээ хүртдэг болоё гэж хэлж буй юм.

Туулын эхэнд нэг, хоёр нуур тогтоох судалгаа, тооцоо бэлэн бий. Туул голоо ингэж ширгэдэггүй, татарч тасардаггүй, цэлэлзсэн устай болгоод нийслэлээ шороон түйрэн, гашуун утаанд багтардаггүй цэвэр, цэмцгэр, цэвэр усан амьсгалтай хот болгоё.

Усан амьсгалтай, байнгын чийгтэй болчвол мод, сөөг ч аяндаа ургана, түймэр ч гарахгүй.

Ерөөсөө монголчууд мөнх тэнгэрийн хүчин доор, хөх усны ивээлд жаргалтай сайхан, баян чинээлэг амьдрах жамтай юм шүү.

Зохиолч, сэтгүүлч Л.Нямготов



Монгол орны оршин тогтнох үндэс нь мал аж ахуй, түүнийг эрхлэн явуулдаг нь малчид. Бид мал сүргээ өсгөөд зогсохгүй эх орноо, элгэн нутгаа, байгаль дэлхийгээ бат зогсон хайрладаг, уул ус хангайгаа хэнээс нь ч илүү хараалан хамгаалдаг байгаль хамгаалагч нар юм. Монгол хүн бүр малчин удамтай. Бидний өвөг дээдэс төрсөн нутгаа сахин хамгаалж, мал сүргээ өсгөн үржүүлсээр мянга мянга жилийг өртөөлсөөр өнөөдрийг хүрчээ. Цаашид ч Монгол оршин тогтнож байгаа цагт нүүдэлч удам тасрахгүй үргэлжилнэ гэдэгт

“НҮЦДЭЛЧИН ТҮМНИЙ ХОЛБОО”-НЫ ТЭРГҮЦН, МАЛЧИН 3.ЦЭНД: Монгол хүн бүр малчин удамтай

бат итгэлтэй явдаг. Малчин бид хаана ямар амьтан хэд байдгийг, хаана ямар өвс ургадагийг, ямар газар нутаглавал мал таргалж тэвээрдэгийг бүрэн мэднэ. Бас хэнийд хаанаас ямар хүн ирснийг, хэн хаашаа явж, хэзээ буцаж ирснийг ч мадаггүй мэддэг болохоор энэ нутагт чухам юу болж буйг сайтар мэднэ. Энэ утгаараа малчид байгаль хамгаалагч төдийгүй хошуу нутгийнхаа манаач нь, сахиул нь, хилчин нь болдогоороо онцлог. Мал сүрэг маань ариун өвс ургамал идэж, цэнгэг ус ууснаараа монгол хүн ариун хоол хүнс хүртэж ирсэн сайхан уламжлалтай. Эдүгээ дээрх боломжууд алдагдсаар, малд элдэв хор хөнөөлтэй эм тариа замбараа хяналтгүй хэрэглэсэнээр бидний идэш хоол мөн адил хортой болдог байна. Монгол хүнийг махгүйгээр төсөөлөхгүй. Мах бол Монголын стратегийн үндсэн хүнс. Төрөөс хатуу хяналт тавих нь зүйтэй. Мал эмнэлэгийн

тогтолцоог дахин сэргээх нь зөв. Малыг эрүүлжүүлдэг хуучны тогтолцоо үнэхээр зөв байсан. Усны бохирдол, бэлчээрийн доройтол нь газар шороотойгоо буруу харьцсаных. Малыг 5000 гаруй жилийн өмнөөс гаршуулж эхэлсэн гэж бодоход бидний дээд өвөг 70 үедээ малаа маллаад эх нутгаа сахин хамгаалж, тусгаар тогтнолоо бэхлээд, малынхаа эрүүл хүнсээ хэрэглэж, энх тунх амьдарсаар ирсэн нь маргашгүй. Нутаг орноо хамгаалагч, мал сүргээ хариулагч, монгол ёс уламжлалаа хадгалан сахигч, нүүдэлчин соёлыг өвлөн тээгчид, хойч үедээ өртөөлөн үлдээж, өвлүүлэгч нар бол малчид. Хамгаас сайхан Монгол орноо хойч ирээдүйдээ бахархалтайгаар үлдээж өгөх нь монгол хүн бүрийн заавал хийх үүрэг, өгөгдөл мөн. Мал хэл хил гуравтай бол хэн баян. Монгол баян. Монгол хүн бүр малчин удамтайгаа дахин санацгаая. Сайхан Монгол орноо хайрлаж босгоцгооё.

САРТ ГОЛ ЦЭЦЭН ВАНГИЙН ХОШУУНЫ ТҮМЭН ОЛНООРОО ИДЭЭ УНДААНЫХАА ДЭЭЖИЙГ ӨРГӨЖ СҮСЛЭН ТАХИЖ ИРСЭН УУЛ, УС МИНУ

Г.Пүрэвдорж Сарт гол цэцэн вангийн хошууны шастир оршвой / УБ., 2017. –296 т. ISBN 978-99978-870-0-09 номоос

Нутгийнхаа уул усыг тахин шүтэж, онгон дагшинаар хайрлан хамгаалж өнөөгийн бидэнд хүргэж ирсэн болохыг олон баримтаар нотолж болно. Тухайлбал, Н.Жалчингомбоцэдэн ноёны Ардын Засгийн газарт хошуу нутаг, албат ард түмнээ хүлээлгэн өгсөн тухай дурсамж ярианаас нэгэн жишээг танд толилуулахаар эл номонд өмнө оруулсан билээ. Манай хошууны хамгийн нандин шүтээн нь нутаг орон, уул ус нь байж ирсэн билээ.

Чин вангийн зэрэг, цэцэн засаг, төрийн бэйл Н.Жалчингомбоцэдэн эзэн ноёныхоо албанаас сайн дураараа бууж, Ардын засагт нутаг орон, албат иргэдээ хүлээлгэн өгөхдөө хэлсэн, “ЗА ӨЛЗИЙ ТОГТОХ МИНЬ! ГАЗАР НУТГИЙГ ЧИНЬ ҮҮЦЭНД НЬ ХАДГАЛЖ ӨДИЙД ХҮРЧ ИРЛЭЭ. ҮҮРЭХ ҮҮРГИЙГ ЧИНЬ ДЭЭДЭС МЭДНЭ БИЗ, ҮҮРЧ ЯВАХ СЭГСЭРЧ ХАЯХАА ӨӨРӨӨ МЭДЭЭРЭЙ. ГАЗРЫН ЧИНЬ ҮҮЦИЙГ ЭВДЭХ ГЭВЭЛ, ГАГЦХҮҮ ХАМЖЛАГУУД ЧИНЬ ЗӨВШӨӨРВӨЛ Л ЗАДЛААРАЙДАА!” гэсэн эрхэм гэрээсийг энд дахин давтан бичье. Манай Монгол үүнийг мартаж болохгүй. Мартвал ...!

Цэцэн Сарт гол хошууны газрын зурагт тус хошууны дотор эрхэмлэн тахиж буй төвийн овоотой бүгд 31 тайлгын овоо бий гэж тэмдэглэжээ. Үүнд:

Эрхэмлэн дагаж, тахиж байсан төвийн овоод бүхий Хан тэнгэрийг мөрлөсөн их Хайрхад нь:

1)Сонгино хайрхан - 48°49'58.16"N; 95°33'25.30"E /Сонгино сум/,

2)Түдэвтэй (Оройн товгор) - 48°31'2.80"N; 96° 9'12.45"E) (уугуул нэр Өндөр цагаан гэдэг байсан) /Цэцэн-уул, Эрдэнэхайрхан сумын заагт/,

3)Шоотой (Байцны дүмбэн) - 48°41'37.63"N; 48°41'37.63"N /Цэцэн-Уул сум/

1)Ханцогт - 47°54'44.76"N;95° 1'24.65"E (одоо Их хайрхан, мөн Алтанмандшир гэх болсон) /Эрдэнэхайрхан сум/,

2) Зогсоо хайрхан - 95° 1'24.65"E; 93°12'43.20"E /Увсын Завхан сум/ болно.

Эдгээр таван их хайрханыг хошуу нийтээр жил бүр тайж тахидаг байсан ба Сонгино хайрханыг ноён уул хэмээн Засаг ноён өөрөө байлцан тахидаг байсан гэнэ.

Монгол орны тахилгатай уулсын овоог 1942 онд үйлдсэн М1:100000 хэмжээстэй Жанжин штабын газрын зурагт тэмдэглэн үлдээжээ. Эдгээр овооны зарим нь үгүй болсон байх агаад мөн цөөнгүй овоо шинээр бий болжээ. Дурдсан газрын зурагт тэмдэглэсэн болон одоо байгаа овоод, сумдын талаар гарсан ном зэргийг ашиглан тус хошууны тахилгатай уул, ус ба түүний овооны байршлыг тодорхойлон хүснэгт үйлдэв.

Сарт гол цэцэн ван Н.Жалчингомбоцэдэний хошууны тахилгатай уул, ус ба түүний овооны байршил

Уул, усны нэр	Овоо байгаа газрын байршил		
Сонгино хайрханы овоо	48°49'58.16"N 95°33'25.30"E	Сонгино хайрханы өвөр бэлд	Сонгино
Түдэвтэйн овоо	48°31'2.80"N 96° 9'12.45"E	Түдэвтэй ноён оргилд	Цэцэн-Уул
Шоотойн овоо	48°41'37.63"N 96°12'3.04"E	Шоотойн хярын ноён оргилд	Цэцэн-Уул
Ханцогтын овоо	Тодорхойлж чадаагүй	Их хайрхан уулын бэлд байсан байх	Эрдэнэхайхан
Зогсоо хайрханы овоо	48°40'23.30"N 93°12'42.60"E	Зогсоо хайрханы баруун хойт оройд	Завхан
Сар хайрханы овоо	48°17'57.36"N 93°33'48.74"E	Сар хайрханы өвөрт	Дөрвөлжин
Сант овоо	47°48'19.68"N 94°12'11.58"E	Их Бууралын зүүн урд Завхан гол хойт дэнжид (Булангийн овоо)	Дөрвөлжин
Ламын овоо	47°45'21.89"N 93°44'51.86"E	Хомын тал Бага нуурын зүүн хойт дэнжид	Дөрвөлжин
Бага нуурын овоо	47°45'40.13"N 93°44'51.86"E	Хомын тал Бага нуурын баруун хойт дэнжид	Дөрвөлжин
Таван толгойн овоо	48° 8'43.20"N 93°54'26.32"E	Завхан голын хойт дэнжид Таван толгой	Дөрвөлжин
Тосонгийн овоо	48°28'8.20"N 96°10'21.84"E	Түдэвтэй уулын өвөр Тосонгийн хярын урд орой	Эрдэнэхайрхан
Түдэвтэйн Цагаан овоо	48°30'52.64"N 96° 4'58.14"E	Түдэвтэй уулын Өргөний модны урд Цагаан овооны хяр	Эрдэнэхайрхан
Хар толгойн овоо**	48°48'59.49"N 93°29'21.06"E	Хүнгийн голын адаг Айраг нуурын хөндийд	Завхан
Бага нуурын Бэрхийн овоо	48°26'46.93"N 95°55'46.92"E	Багануурын Бэрх уулын орой	Эрдэнэхайрхан
Шавагийн овоо	48°34'4.55"N 94°1'21.27"E	Хүнгийн гол хойт дэнж	Ургамал
Хутаг уулын овоо	48°23'15.36"N 94°18'3.95"E	Ургамал сумын төвөөс урагшаа Хутаг уулын оройд	Ургамал
Цагаан овоо	48°25'2.28"N 94°30'13.71"E	Талын улааны баруун талд Авгайн харын хойно	Ургамал
Хулжийн овоо	48°46'55.79"N 94° 7'15.99"E	Хулжийн голын эхний булгуудын урд талд 1211.2 өдөр толгойн оройд (Хулжийн овоо) Увс аймгийн нутагт	Ургамал
Бууралын Цагаан овоо	48°0'34.93"N 94°28'2.94"E	Их буурал уулын оройд	Завханмандал
Мандлын овоо	48°20'55.27"N 94°50'0.45"E	Мандал багийн зүүн тал, Хүнгийн голын урд дэнжид	Завханмандал
Цэцэн хайрхан	48°44'14.06"N 95°47'7.84"E	Цэцэн хайрханы хярд	Цэцэн-Уул
Агийн овоо	48°39'57.20"N; 95°45'21.44"E	Цэцэн хайрханы урд бэлд	Цэцэн-Уул
Шоотойн овоо	48°41'48.62"N 96° 5'58.68"E	Цэцэн-Уул сумын төвийн урд талд байх	Цэцэн-Уул

Батсуурийн овоо	48°45'58.80"N 95°57'44.10"E	Цэцэн-Уул сумын төвийн хойт талын Батсуурь уулын орой	Цэцэн-Уул
Бүрэгтэйн овоо	48°34'15.51"N 96° 4'28.03"E	Түдэвтэй ард Галуутай голын урд Бүрэгтэй уул	Цэцэн-Уул
Шар нурууны овоо	48°50'10.04"N 96°12'24.73"E	Шар нурууны Мөсөнгийн урд хярд	Сонгино
Шар нурууны Бэйсийн овоо	48°51'37.94"N; 96°15'46.38"E	Шар нурууны Гэлэнтийн урд хярд	Түдэвтэй
Шар нурууны Мөсөнгийн овоо	48°51'55.79"N; 96° 9'27.58"E	Мөсөнгийн овооны хярд	Сонгино
Айраг нуурын овоо	48°59'9.97"N 96° 5'51.54"E	Айраг нуурын урд Овоон дэлийн оройд	Сонгино
Өвгөн уулын овоо	48°55'35.78"N96° 1'4.42"E	Өвгөн уулын хярд	Сонгино сум
Өвгөн уулын Хайсан давааны овоо	48°54'35.77"N 96° 5'56.93"E	Нарангийн модны эхэнд Хайсан даваанд хярд	Сонгино
Мангины овоо	48°54'23.91"N 95°46'51.20"E	Мангины оройд	Сонгино
Улаагчны овоо	48°39'21.27"N 96°31'12.89"E	Улаагчин уулын оройд	Түдэвтэй
Сантын овоо	48°29'25.15"N 95° 8'7.02"E	Баян нуурын ард Сант уулын оройд	Сантмаргац
Хойт овоо	48°36'34.33"N 95°24'21.35"E	Холбоо нуурын хойно	Сантмаргац
Алаг овоо	48°34'23.99"N; 95°22'58.41"E	Холбоо нуурын зүүн хойт талын уул	Сантмаргац
Нарийны овоо	48°19'39.17"N 96°42'0.29"E	Элст нарийн голын зүйн эхний ууланд	Яруу
Есөн индэртийн овоо	48°19'53.63"N 96°48'24.27"E	Ар хужиртын гол, Нарийн голын завсарын Есөн индэрт уулын оройд	Яруу
Хаг нуурын овоо	48°4'29.23"N 96°35'40.69"E	Хаг нуурын хойт дэнжид	Яруу
Нарийны овоо	48°19'39.17"N 96°42'0.29"E	Яруугийн төвөөс хойш Элст нарийны голын эхэний зүүн хойт талын 2576.5 м өндөр оргилын оройд	Яруу
Хэрсэнгийн овоо	48°11'58.84"N; 96°42'38.96"E	Хойт Хүрэнбухатын хойно Хэрсэн толгойн зэргэлдээ Ар хужиртын голын зүүн талаас шахсан толгой	Яруу
Зүйлийн овоо	48° 4'53.55"N 96°23'52.77"E	Зүйлийн голын эх Хүйс толгойн оройд	Яруу
Бугатын овоо	48°20'4.00"N 96°27'36.52"E	Бугатын хярд	Яруу

***1942 онд үйлдсэн М1:100000 хэмжээстэй Жанжин штабын газрын зурагт тэмдэглэсэн овоодыг сансрын зурагтай харьцуулан байршлыг тодорхойлов.**

**** Завхан, Хүнгийн голын адагт Хар толгойн овоо орчимд 26 овоо байжээ.**